



**УЛААНБААТАР
ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2021 оны 02 сарын 05 өдөр

Дугаар 6/45

Улаанбаатар хот

Г.Базаргүрт буцалтгүй
тусламж үзүүлэх тухай

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.11.11, компанийн Захиргаа-Үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулсан 2019-2020 онд мөрдөх Хамтын гэрээний 5 дугаар зүйлийн 5.10.1.3 дахь заалт, Захирлын зөвлөлийн хурлын 2021 оны 02 дугаар сарын 04-ны өдрийн 7 дугаар шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Техникийн бодлого зохицуулалтын хэлтсийн өндөр настан Г.Базаргүрт салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ /672000 төгрөг/-г 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламжийг үзүүлсүгэй.

2. Буцалтгүй тусламжийн 1 344 000 /нэг сая гурван зуун дөчин дөрвөн мянга/ төгрөгийг ажиллагсдын нийгмийн зардлаас гаргахыг Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч /О.Ариунболд/-д зөвшөөрсүгэй.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Р.ДАГДАН